



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/671

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэх тухай" 124 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дахь заалт, "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн 7.5.1 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 39 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, дотуур байр, биеийн тамирын заалны орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээний худалдан авах ажиллагааны гэрээг шууд байгуулж гүйцэтгүүлэх эрхийг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т шилжүүлсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар), Ерөнхий боловсролын сургуулиудын захирлуудад тус тус үүрэг болгосугай.


3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/519, 2023оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/589, А594, 2023 оны 12 сарын 12-ны өдрийн А/661, А/662 дугаар бүхий захирамжуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын Далай ОНЫ
18 дугаар сарын 18 ны өдрийн 671
дугаар захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД
САНХҮҮЖИХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Сургуулийн нэр	Төсөл арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг (төгрөг)
				Эхлэх	Дуусах	
1	Бугат	Бугат сумын ерөнхий боловсролын сургууль	Бугат сумын сургуулийн засварт	2023	2023	5,000,000
2	Бугат	Бугат сумын Тахийн тал багийн бага сургууль	Бугат сумын Тахийн тал багийн сургуулийн засварт	2023	2023	3,000,000
3	Тонхил	Тонхил сумын ерөнхий боловсролын сургууль	Тонхил сумын Алтансоёмбо багийн сургуулийн засварт	2023	2023	5,000,000
4	Цогт	Цогт сумын Баянтоорой тосгоны ерөнхий боловсролын сургууль	Баянтоорой тосгоны сургуулийн халаалтын засвар	2023	2023	8,300,000
5	Дэлгэр	Дэлгэр сумын ерөнхий боловсролын сургууль	Дэлгэр сумын сургуулийн тохижилт	2023	2023	19,000,000
6	Жаргалан	Жаргалан сумын ерөнхий боловсролын сургууль	Жаргалан сумын сургуулийн тохижилт	2023	2023	5,000,000
Нийт						45,300,000